



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/631.

Ховд


Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны “Аймгийн 2020 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулж батлах” 11/02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Болор цомын шагналт яруу найрагч Г.Сэр-Одын нэрэмжит яруу найргийн тэмцээн болон “Гүн галуутайн цом-37” яруу найргийн Болор цомын 2020 оны наадмын тэргүүн шагналт Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын уугуул иргэн, Монголын Үндэсний Орон нутгийн Радиогийн найруулагч Хар бургууд овогт Дашнямын Жамбалдоржийн Монголын уран зохиол, яруу найргийн салбарт гаргасан амжилт, орон нутагт уран зохиол, яруу найргийг хөгжүүлэх үйлсэд оруулсан хувь нэмэр, хөдөлмөрийн үр дүнг өндрөөр үнэлэн орон сууцны дэмжлэгт 30.0 сая төгрөг /гучин сая/-ийг олгосугай.

2.Тус арга хэмжээнд зарцуулах 30.0 сая төгрөгийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр арга хэмжээний 5.24-д баталсан “Чадварлаг Ховдчууд” хөтөлбөрийн арга хэмжээнээс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Зах А/631 Чх  
02 2352